



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Г Хорооны 2011 оны 45 дугаар тогтоолын 7
хавсралтад нэмэлт оруулах тухай

Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн 2011 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Гомдлыг хангаж, шийдвэрийг хүчингүй болгох тухай” 12 дугаар тогтоол батлагдсаныг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Банкны тухай хуулийн 6.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д дор дурьдсан агуулгатай 1.11 дэх хэсгийг нэмсүгэй:

1/ “1.11 Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ гэдэгт дараах ажил үйлчилгээг ойлгоно:

1.11.1. Үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах,

1.11.2. Хорооны 2008 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх тухай түр журам”-д заасан ажил үйлчилгээ,

1.11.3. Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа,

1.11.4. Хорооноос тогтоосон бусад ажил үйлчилгээ”.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН